

АКАДЕМИЧ ЧУЛУУНЫ ДАЛАЙ (1930-2009)



Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишүүн, манай улсын нэртэй түүхчдийн нэг, Шангас овгийн Чулууны Далай 2009 оны зургаадугаар сарын 12-ны өдөр өвчний улмаас таалал төгсч ертөнцийн мөнх бусыг үзүүлээ.

Ч.Далай 1930 онд Ховд аймгийн Зэрэг суманд төрж, 1950 онд Ховд аймгийн 10 жилийн дунд сургууль, 1958 онд Бээжин их сургуулийг түүхийн мэргэжлээр төгсчээ.

Ч.Далай МУИС-д түүхийн багш, ШУА-ийн Түүхийн хүрээлэнд эрдэмтэн нарийн бичгийн дарга, захирал, БНМАУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, зөвлөх, ШУА-ийн дэргэдэх Дорнодахины судлалын хэлтсийн эрхлэгч, Дорно дахины судлалын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төв, Олон улс судлалын хүрээлэнгийн зөвлөхөөр тус тус ажиллаж байлаа.

Ч.Далай 1970 онд “Юан гүрний Монгол” сэдвээр түүхийн ухааны дэд доктор, 1986 онд “Монгол-Хятадын харилцаа (1949-1984)” сэдвээр докторын зэрэг хамгаалжээ. 1990 онд профессор цол хүртэж, 1993 онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишүүнээр сонгогдсон байна.

Тэрээр Монголын Үндэсний түүхчдийн холбооны Ерөнхийлөгч, ШУА-ийн Түүхийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргын сонгуульд албыг нэр төртэй хашиж байлаа.

Ч.Далай нь шинжлэх ухааны байгууллагад 40 гаруй жил үр бүтээлтэй ажиллаж, “Монголын Бөө мөргөлийн товч түүх”, “Юань гүрний үеийн Монгол”, “Хамаг Монгол Улс /1101-1206/”, “Монголын түүх /1260-1388/”, “Их Монгол Улс /1206-1388/”, “Өгөөдэй хаан”, “Ойрадын түүх” зэрэг судалгааны үнэ цэнэтэй 100 гаруй бүтээл туурвиж, Монголын түүхийн нэн чухал үеүдийн зарим бүдэг асуудлуудыг тодруулах, түүх бичлэгт шинэ сэтгэлгээ оруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн манай нэртэй түүхчдийн нэг билээ. Мөн түүхчдийн залуу халааг бэлтгэх, Монгол Улсад орон судлалыг үүсгэн хөгжүүлэхэд

жинтэй хувь нэмэр оруулжээ. Түүний хөдөлмөр бүтээлийг төр засаг өндөр үнэлж, Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол, “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн” одонгоор шагнажээ.

Талийгаачийн мятаршгүй хөдөлмөрч, үнэнч шудрага, эгэл даруу, нийтэч, нөхөрсөг тусч зан чанар, гэгээн дүр төрх бидний зүрх сэтгэлд мөнхрөн үлдэх болно.

Н.Энхбаяр, Д.Дэмбэрэл, С.Баяр, Ц.Элбэгдорж, Р.Амаржаргал,
С.Бямбацогт, Ё.Отгонбаяр, Д.Ширэндэв, Н.Нямдаваа, Б.Чадраа,
Б.Энхтүвшин, Ш.Бира, Л.Хайсандай, Ч.Дашдаваа
ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн хамт олон